



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024 08.19 № 686

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Д.Нармандах сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021367

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Д.Нармандах аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Д.Нармандахын мөрийн хөтөлбөр (.....<sup>1</sup>.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Д.Нармандахад

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2024 ОНЫ СОНГУУЛЬД БАЯН-АГТ СУМААС БИЕ ДААН  
НЭР ДЭВШИГЧ ДАМДИНСҮРЭН ОВОГТОЙ НАРМАНДАХЫН  
“НУТГИЙН ХӨГЖИЛ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.08.06

Булган аймаг

Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр болон бусад хууль тогтоомжийн хүрээнд олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогыг зүй зохистой хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийн язгуур эрх ашгийг дээдлэж ажилтай, орлогтой болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Би “НУТГИЙН ХӨГЖИЛ” гэсэн уриаг дэвшүүлж, аймаг, сумын хөгжил, ард иргэдийн ирээдүйдээ итгэлтэй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг иргэдийн санал хүсэлт дээр үндэслэн боловсруулсан.

Мөрийн хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх ба орон нутгийн иргэдийн эрх ашгийг нэн түрүүнд тавих тэднийг амжилтанд хүргэх, ашиг орлогоо дээшлүүлэхэд чиглэсэн бодит ажлуудыг дэвшүүлж байна.

1. Хүний эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр гаргасан бодлого зорилтыг бодлогоор дэмжинэ.
2. Боловсролын байгууллагын сургалтын чанар, суралцах орчинг сайжруулахад анхаарч, хувиарлагдсан хөрөнгө оруулалтыг тэгш хүртээмжтэй хувиарлахыг баримтлан ажиллана.
3. Орон нутгийн түүхий эд, нөөц боломжинд тулгуурласан зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх мөн аймгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг бодлогоор дэмжинэ.
4. Аялал жуулчлалын дотоод гадаадын аялагчдад зориулсан аялалын маршрутыг сонирхол хэрэгцээнд нь тулгуурлан ногоон өв соёлыг хэвшүүлэхийг баримтлан ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ



Д.НАРМАНДАХ

РД: ГА83071779

Утас: 99026405